



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 01 сарын 11 өдөр

Дугаар Б/01

Чингис хот

Д.Амгаланбаатарыг орон  
тооны зөвлөхөөр томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төрийн албаны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3, Хөдөлмөрийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын бүрэн эрхийн хугацаанд зөвхөн өөрт нь үйлчлэх орон тооны зөвлөхөөр Дагдандоржийн Амгаланбаатарыг 2021 оны 1 дүгээр сарын 11-ний өдрөөс эхлэн томилсугай.

2. Албан үүргээ холбогдох хууль тогтоомжийн хүрээнд гүйцэтгэж, аймаг орон нутгийн хөгжлийн бодлого, төлөвлөлтийн талаар судалгаа, шинжилгээ хийх, төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх ажилд анхаарч ажиллахыг аймгийн Засаг даргын орон тооны зөвлөх Д.Амгаланбаатарт үүрэг болгосугай.

3. Аймгийн Засаг даргын зөвлөх Д.Амгаланбаатарын үндсэн цалинг 420.000 /дөрвөн зуун хорин мянган/ төгрөгөөр тогтоож, батлагдсан төсөвт багтаан цалинжуулж, хөдөлмөрийн гэрээ байгуулж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Ж.Ганбаатар/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ИДЭРБАТ

• 231010031